



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.2, 11.3.3 дахь заалт, Улсын онцгой комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д зааснаас бусад аймагт гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цагаас эхлэн бууруулж, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

4. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэл, Архангай, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.

5. Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон аймгийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, халдварт хамгааллын дэглэм, горимыг чанд мөрдөж ажиллахыг дээрх аймгийн Засаг дарга наарт үүрэг болгосугай.


6. Халдвартын сэжигтэй болон батлагдсан тохиолдол шинээр бүртгэгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.3.1, 11.3.2-т заасны дагуу холбогдох бэлэн байдлын зэрэгт шилжуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг тухайн шатны онцгой комиссын дарга наарт даалгасугай.

7. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан хязгаарлалтыг авч, халдварт хамгааллын дэглэмийг мөрдүүлэх, бүх шатны боловсролын байгууллага, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоо чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч

ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт даалгасугай.

9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайд

Я.СОДБААТАР



Засгийн газрын 2020 оны 194 дүгээр
тогтоолын хавсралт

**ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ**

№	ҮЙЛ АЖИЛЛАГАА
1.	Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа
2.	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
3.	Газрын тосны бүтээгдэхүүн, түлшний хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
4.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа
5.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, ханган нийлуулэх үйл ажиллагаа
6.	Банк санхүү, хөрөнгийн биржийн үйл ажиллагаа
7.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудан, илгээмжийн үйл ажиллагаа
8.	Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын үйл ажиллагаа
9.	Малын ёвс, тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
10.	Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа
11.	Арьс шир, ноос, ноолуурын боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа
12.	Сав баглаа боодол, хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаа
13.	Модон здлэл, барилгын хийц, материалын үйлдвэрийн үйл ажиллагаа
14.	Бараа материалын цахим худалдаа, хүргэлтийн үйл ажиллагаа
15.	Хууль тогтоох дээд байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн захираганы байгууллагын үйл ажиллагаа (тооны хязгаарлалттай)
16.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
17.	Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын үйл ажиллагаа
18.	Оршуулгын үйл ажиллагаа

Б хязгаарлалттай төрийн байгууллагын тогтоох төслийн үйл ажиллагаа
ийн тогтоох дээд байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн
захираганы байгууллагын үйл ажиллагаа (тооны хязгаарлалттай)
тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
шүүх, прокурор, өмгөөлөл, нотариатын үйл ажиллагаа
оршуулгын үйл ажиллагаа